

**МОНГОЛ УЛСААС ГАДААД УЛСАД СУУХ ЗАРИМ ЭЛЧИН САЙД НАРЫГ
ТОМИЛОХ, ЭГҮҮЛЭН ТАТАХ САНАЛЫГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 05 дугаар
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сэсээрийн Золжаргал, Монгол Улсаас Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Банзрагчийн Баярсайхан, Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батнямын Энхбат, Монгол Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Эрдэнэцогтын Сарантогос нарыг томилох, Монгол Улсаас Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийням, Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шагдарын Батцэцэг, Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбадаржаагийн Батжаргал, Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрдэнэцогтын Сарантогос, Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ядмаагийн Ариунболд нарыг эгүүлэн татах саналыг 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад улсад суух зарим элчин сайд нарыг томилохоор оруулж ирсэн саналыг дэмжиж байгаагаа илэрхийлээд, гадаад валютын нөөц, хөрөнгө оруулалт буурч байгаа тул гадаад бодлогыг эдийн засагжуулах ажлыг эрчимжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд дайн, геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалж том гүрнүүд холбоотон, түнш улстайгаа хамтран ажиллах бодлогодоо өөрчлөлт оруулж байгаа тул тухайн улс орон гадаад бодлогодоо ямар байр суурьтай байна вэ гэдэгт мэргэжлийн үүднээс хандах, холбогдох яам, иргэдтэйгээ нягт хамтран ажиллах шаардлагатай болохыг нэр дэвшигчдэд анхааруулсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн С.Батболд Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон үндсэн зорилтын хүрээнд эдийн засгийн хамтын ажиллагаа, гадаад худалдааг улам эрчимжүүлэх, Бүгд Найрамдах Солонгос Улстай харилцан ярилцаж байгаа визний асуудлыг урагшлуулах, Канад Улстай уул уурхай, хөдөө аж ахуйн чиглэлээр урт болон дунд хугацаанд хамтран ажиллах суурь нь тавигдсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, цаашид эрчимжүүлэх нь зүйтэй болохыг онцлон тэмдэглэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн Сэсээрийн Золжаргалыг Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Банзрагчийн Баярсайханыг Монгол Улсаас Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Батнямын Энхбатыг Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Эрдэнэцогтын Сарантогосыг Монгол Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар тус тус томилохыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжсэн болно.


Түүнчлэн Монгол Улсаас Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийням, Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шагдарын Батцэцэг, Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбадаржаагийн Батжаргал, Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрдэнэцогтын Сарантогос, Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ядмаагийн Ариунболд нарыг эгүүлэн татах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох саналыг зөвшилцсөн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.ЭНХ-АМГАЛАН